



МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2013 оны 02 сарын 06 өдөр

Дугаар 39

Улаанбаатар хот

Г

Т

Хорооны 2006 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан
журамд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.2, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 34.1.3 дахь заалтыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. Санхүүгийн зохицуулах хорооны 2006 оны 8 дугаар сарын 04-ний өдрийн 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Үнэт цаасны зах зээлд мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн тухай журам”-д дор дурдсан агуулга бүхий 1.8, 2.1.13, 2.5.4, 8.2.9, 11.11.4, 11.14 дэх заалтуудыг тус тус нэмсүгэй:

1/ 1 дүгээр зүйлийн 8 дахь заалт:

“1.8. үнэт цаасны зах зээлд мэргэжлийн үйл ажиллагаа явуулдаг дотоод, гадаадын хуулийн этгээд нь өөр улсын үнэт цаасны зах зээлд Монгол Улсын иргэдэд хувьцаа худалдан авахад зуучлах үйл ажиллагаа эрхлэх тохиолдолд Хороонд бүртгүүлнэ. /Хороо шаардлагатай гэж үзвэл нэмэлт баримт, лавлагааг шаардаж болно./”

2/ 2 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 13 дахь заалт:

“2.1.13. мэргэжлийн байгууллагын гүйцэтгэх захирал, мэргэжилтнүүд давхар ажил, хөдөлмөр эрхэлдэггүй, өөр мэргэжлийн байгууллагын 5 хувь ба түүнээс дээш хувийг эзэмшдэггүй, тэдгээрт эрх бүхий албан тушаал эрхэлдэггүй байх.”

3/ 2 дугаар зүйлийн 5 дахь хэсгийн 4 дэх заалт:

“2.5.4. Брокер, дилерийн тусгай зөвшөөрөл шинээр хүссэн хуулийн этгээд нь үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллага /Хөрөнгийн бирж/-ын гишүүнчлэлийн журамд заасан нөхцөл, шаардлагыг хангасан талаарх тухайн байгууллагын дүгнэлтийг Хороонд ирүүлнэ.”

4/ 8 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 9 дэх заалт:

“8.2.9. харилцагчдад хохирол учруулсан нь хууль хяналтын байгууллагын шалгалт, шийдвэрээр тогтоогдсон”.

5/ 11 дүгээр зүйлийн 11 дэх хэсгийн 4 дэх заалт:

“11.11.4. Хорооноос тухайн компанид салбар нээн ажиллуулахыг зөвшөөрсөнөөс хойш 3 сарын хугацаанд тухайн орон нутагт салбар нь үйл ажиллагаа явуулаагүй, мөн түүнчлэн салбарын үйл ажиллагааг явуулж байгаад 3 сараас дээш хугацаагаар зогсоосон;”

6/ 11 дүгээр зүйлийн 14 дэх заалт:

“11.14. Орон нутагт бүртгэлтэй эсхүл тухайн орон нутагтаа үйл ажиллагаа эрхлэхээр тусгай зөвшөөрөл авсан мэргэжлийн байгууллага нь Улаанбаатар хотод салбар нээх тохиолдолд журмын 2 дугаар зүйлд заасан шаардлагыг хангасан байна.”.

2. Мөн журмын 8 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2 дахь заалтын “4” гэснийг “3” гэж, мөн хэсгийн 3 дахь заалтын “4” гэснийг “3” гэж тус тус өөрчилсүгэй.

3. Мөн журмын 2 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 3, 5 дахь заалтуудыг дор дурьдсан агуулгаар тус тус өөрчлөн найруулсугай:

1/ 2 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 3 дахь заалт:

“2.1.3. Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 19.2.11-д заасны дагуу брокер, дилер, андеррайтерийн компани нь хувь нийлүүлсэн хөрөнгийн 3-аас доошгүй хувьтай тэнцэх мөнгөн хөрөнгөөр эрсдлээс хамгаалах сан байгуулж, сангийн хөрөнгийг өөрийн тусгайлсан дансанд тогтмол байршуулах.

Эрсдлээс хамгаалах сангийн хөрөнгийг зөвхөн компани, түүний албан тушаалтнуудын буруутай үйл ажиллагаанаас харилцагчдад учруулсан хохирлыг барагдуулахад зарцуулах бөгөөд уг хохирлыг Хорооны улсын байцаагчийн шалгалтаар тогтоож, захиргааны хэрэг бүртгэх ажиллагаа явуулж албан шаардлагаар барагдуулахыг үүрэг болгосон байна. Сангийн мөнгөн хөрөнгө энэхүү журамд заасан хэмжээнээс багассан тохиолдолд ажлын 5 хоногийн дотор тогтоосон хэмжээнд нөхөн байршуулна.”.

2/ 2 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5 дахь заалт:

“2.1.5. дотоод хяналтын үйл ажиллагааг хэрэгжүүлэх орон тооны ажилтантай байх бөгөөд Хорооноос олгосон мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх эрхтэй, гүйцэтгэх захирал, брокер, дилер, үнэлгээ, төсөл, судалгаа, хөрөнгө оруулалтын зөвлөхийн чиглэлийн ажил үүргийг хавсран эрхэлдэггүй байх;”